



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

"Дарь эх ундрага хоёр" ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох,
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 4.1 дэх хэсэг, Хорооны 2012 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам"-ын 1.2, 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарь эх ундрага хоёр" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Дарь эх ундрага хоёр" ХЗХ /С.Мягмаржав/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000604